

Бяцхан хүүхдүүдэд хайртай Есүс

-Jesus loves the little Children-



17Page

Тайлбарлагч Есүс тэнгэр улсын тухай, Бурханы үгийг дамжуулахаар дагалдагч нарын хамт Иудейгийн тосгонд очив. Есүсийн явсан газар бүрд үргэлж олон хүн даган, цугладаг байлаа. Тэдний дунд бяцхан хүүхдүүдээ дагуулж ирсэн хүмүүс ч байлаа.

Эцэг, эх Ингэж нэг Есүс манай тосгонд ирдэг байжээ.

Эцэг, эх Хурдан очоод Есүсийг тосон мэндчилээд, Түүний үг сургаалыг сонсцгооё

Хүүхэд За

Тайлбарлагч Есүстэй уулзана гэж сонсоод бяцхан хүүхэд маш их баярлав.



18Page

Тайлбарлагч Замын цаанаас Есүс ирж яваа нь харагдав. Бяцхан хүүхдүүд баярлан гүйлдэж Түүний хажууд ойрхон очлоо. Гэтэл хүүхдүүдийг Есүст ойртуулахгүйн тулд дагалдагч нар нь тэднийг хориглов.

Дагалдагч 1 Есүс чухал ажил хийж байхад хүүхдүүд дагуулж ирнэ гэнээ. Болохгүй, болохгүй.

Дагалдагч 2 Хүүхдүүд шуугилдаж, үймүүлдэг учраас Есүс ч бас дургүйцэх байх. Тиймээс цаашаа явцгаа.

Хүүхэд Би Есүстэй уулзмаар байнаа.... ий, ий, ий



19Page

Тайлбарлагч Энэ байдлыг харсан Есүс дагалдагч нараа уурлан зэмлэв. Бяцхан хүүхдүүдийг над руу ирэхийг нь зөвшөөр! Бурханы хаанчлал бол хүүхэд шиг сэтгэлтэй хүмүүсийнх юм. Дагалдагч нар минь би үнэнээр үнэнээр та нарт хэлж байна. Бяцхан хүүхэд шиг итгэлтэй бай. Ийм итгэлгүйгээр хэн ч Бурханы хаанчлалд орж чадахгүй.

Тайлбарлагч Ингэж хэлээд Есүс хүүхдүүд руу хоёр гараа сунган дэлгэв. Хүүхдүүд Түүнд тэврүүлэхэд Тэр тэднийг ерөөн адисллаа.

Хүүхэд 1 Хөөх, Есүсийн сахал ямар гоё юм бэ?

Хүүхэд 2 Есүс ээ, та дахиад сонирхолтой зүйл яриад өгөөч.

Есүс Аан за за, тэгэлгүй яахав. (инээх)

Тайлбарлагч Есүс очсон газар болгондоо хүүхдүүдийг хайрлаж байлаа.



20Page